



МОНГОЛ УЛС  
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/206

Чингис хот

Ц.Отгонбатад газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажил хэрэгжсэнтэй холбогдуулан иргэн Цэдэв овогтой Отгонбатад 709 м<sup>2</sup> газрыг эзэмшүүлсүгэй.

2. Иргэн Ц.Отгонбатын эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн Ц.Отгонбатад үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/367 дугаар захирамжуудыг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

10535